

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Засгийн газрын нөөц сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/12/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхбаатар Утас: 261740 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn Аудитор: О.Наранбат Утас: 261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ж.ГАНБАТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV баир
Угас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25

№

07/810

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Засгийн газрын нөөц сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Засгийн газрын нөөц сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 50 тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас зарцуулалт гаргах эрхийг олгосон байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын тогтоолоор гамшиг, аюулт үзэгдэл, түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгахад 26,203,419.6 мянган төгрөг, Улсын их хурал, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд 43,853,110.4 мянган төгрөг, олон улсын шүүх, арбитраж хариуцагчаар татагдсан, тэдгээрээс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд 9,943,470.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Z:\Yawsan_Bichig\2024\0229 SNAG-37.Docx

0001051837

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
33	АВЛАГА	-	-
33500	Бусад авлага	-	-
33510	Байгууллагаас авах авлага	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
41300	Өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	-
51	Засгийн газрын хувь оролцоо	-	-
51200	Хуримтлагдсан үр дүн	-	-
51210	Өмнөх үеийн үр дүн	-	-
51220	Тайлант үеийн үр дүн	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	-

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	61,200,000,000.00	80,000,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	61,200,000,000.00	80,000,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	61,200,000,000.00	80,000,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	61,200,000,000.00	80,000,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	61,200,000,000.00	80,000,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,200,000,000.00	80,000,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,178,713,152.46	80,000,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,178,713,152.46	80,000,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,178,713,152.46	80,000,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,286,847.54	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,286,847.54	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	21,286,847.54	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	61,640,750,764.81	81,075,426,134.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	440,750,764.81	1,075,426,134.33
120	Нийтлэг татварын бус орлого	440,750,764.81	1,075,426,134.33
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	440,750,764.81	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	440,750,764.81	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	61,200,000,000.00	80,000,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	61,200,000,000.00	80,000,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	61,200,000,000.00	80,000,000,000.00

Засгийн газрын нөөц сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,640,750,764.81	81,075,426,134.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,640,750,764.81	81,075,426,134.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,640,750,764.81	81,075,426,134.33
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,640,750,764.81	81,075,426,134.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,640,750,764.81	81,075,426,134.33
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗГ-ын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	ЗГ-ын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
2023 оны 12-р сарын 31- нэрэх үлдэгдэл	-	-	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	80,000,000,000.00	80,000,000,000.00	-	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,000,000,000.00	80,000,000,000.00	-	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,000,000,000.00	80,000,000,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,000,000,000.00	80,000,000,000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,000,000,000.00	80,000,000,000.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	80,000,000,000.00	80,000,000,000.00	-	100.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	80,000,000,000.00	80,000,000,000.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	80,000,000,000.00	80,000,000,000.00	-	100.0

Засгийн газрын нөөц сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 544.3 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 544.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал төсвөөс санхүүжүүлэх боломжтой 2,369,882.6 мянган төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас зарцуулсан байна.	1	-					1	-				
Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар санхүүжилтийг нь баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 544,258.2 мянган төгрөгийн санхүүжилтийг ЗГНС-аас нэмэлтээр олгосон байна.	1	544,258.2					1	544,258.2				
Дүн	2	544,258.2	-	-			2	544,258.2				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.